

# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*2024 оны III улирлын санхүүгийн тайлан*

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын  
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт .....	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт .....	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт .....	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт .....	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт .....	8
Статистик үзүүлэлтүүд .....	9
Харилцагчид, зээлдэгчид .....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид .....	9
Тархалт .....	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт .....	12
Зээл.....	13
<b>Цахим зээл</b> .....	16
<b>Ногоон зээл</b> .....	18
Факторингийн тооцооны авлага.....	19
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	19
Санхүүгийн бус хөрөнгө .....	20
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт .....	21
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	22
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	23
Бусад эх үүсвэр .....	23
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	24
Төслийн зээлийн санхүүжилт .....	24
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ).....	25
Бусад санхүүгийн өр төлбөр.....	25
Санхүүгийн бус өр төлбөр.....	25
Өөрийн хөрөнгө .....	26
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	26
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг .....	27
Хуримтлагдсан ашиг .....	27
Ашигт ажиллагаа .....	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	30
Дүгнэлт .....	31
Актив, пассивын бүтэц.....	31
Ашигт ажиллагаа .....	32
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	32

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл .....	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр).....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа .....	5
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл (5 жилээр) .....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл .....	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт .....	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт .....	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	11
Хүснэгт 12 Активын интервал (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр) .....	12
Хүснэгт 14 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр) .....	13
Хүснэгт 15 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр) .....	13
Хүснэгт 16 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр) .....	15
Хүснэгт 17 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр) .....	15
Хүснэгт 18 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр) .....	16
Хүснэгт 19 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр).....	16
Хүснэгт 20 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр).....	18
Хүснэгт 21 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр) .....	19
Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	19
Хүснэгт 23 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр) .....	20
Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр) .....	21
Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр) .....	23
Хүснэгт 27 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (тэрбум төгрөгөөр).....	23
Хүснэгт 28 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр) .....	23
Хүснэгт 31 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр) .....	25
Хүснэгт 32 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр).....	25
Хүснэгт 33 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр).....	25
Хүснэгт 34 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр) .....	26
Хүснэгт 35 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	26
Хүснэгт 36 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр).....	27
Хүснэгт 37 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр).....	27
Хүснэгт 38 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр) .....	27
Хүснэгт 39 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Хүснэгт 40 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр) .....	29
Хүснэгт 41 Орлого, үр дүнгийн тайлан (сая төгрөгөөр).....	29
Хүснэгт 42 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр).....	30

## Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр) .....	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	12
Зураг 5 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр) .....	14
Зураг 6 Зээлийн багцын чанар (хувиар) .....	14
Зураг 7 Олгосон зээл (хугацааны ангиллаар).....	15
Зураг 10 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар) .....	18
Зураг 11 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	21
Зураг 12 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	22
Зураг 13 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр) .....	22
Зураг 14 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр) .....	24
Зураг 15 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)...	24
Зураг 16 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр) .....	26
Зураг 17 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр).....	29

## Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
СТ	Санхүүгийн тайлан
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЗМС	Зээлийн мэдээллийн сан

## Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2024 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 555 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 34 ББСБ буюу 6.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 98 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2020-III	2021-III	2022-III	2023-III	2024-III
Шинээр олгосон	12	9	14	18	39
Хүчингүй	8	10	26	10	13
Түдгэлзүүлсэн	25	20	57	12	20
Сэргээсэн	4	6	19	17	14
<b>Нийт ББСБ</b>	<b>533</b>	<b>531</b>	<b>522</b>	<b>521</b>	<b>555</b>
Үүнээс: ХОН	77	80	91	93	98
Үүнээс: ГХО	29	29	26	25	26
Салбар	285	313	419	453	455
Төлөөлөгч	9	8	7	11	12

2024 оны III улирлын байдлаар 39 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 13 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 20 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 14 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2024 оны III улирлын байдлаар 62 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2023-III	2024-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	4,257.4	6,417.6	50.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	8.6%	10.2%	1.6%
Нийт өөрийн хөрөнгө	2,589.6	3,379.3	30.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	49.1%	52.1%	3.0%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,453.0	1,714.9	18.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	87.5%	99.4%	11.9%
Нийт зээл	3,378.5	5,198.2	53.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	12.8%	14.6%	1.8%
Нийт орлого	814.7	1,282.6	57.4%
Нийт зарлага	512.3	783.3	52.9%
Цэвэр ашиг	302.4	499.3	65.1%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар өсөж, банкны салбарын 10.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 99.4%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.9 пунктээр өссөн дүн юм.

2024 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсөж 6.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 84.2 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 36.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 57.4 хувиар буюу 467.9 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 52.9 хувиар буюу 271.0 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 65.1 хувиар буюу 499.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2023-III	2024-III	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	521	555	34	6.5%
1	Зээл	484	492	8	1.7%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	316	297	-19	-6.0%
2	Факторингийн үйлчилгээ	43	63	20	46.5%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	28	-	-
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	6	1	20.0%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	37	53	16	43.2%
6	Гадаад арилжаа валютын арилжаа	140	176	36	25.7%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	38	60	22	57.9%
7	Итгэлцлийн үйлчилгээ	61	90	29	47.5%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	22	43	21	95.5%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 555 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 88.6% нь буюу 492 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 53.5% нь буюу 297 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 176 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 31.7 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 60 ББСБ нийт ББСБ-уудын 10.8 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 6.0 хувиар буурч бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл гадаад валютын арилжаа 36 ББСБ-аар буюу 25.7 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 29 ББСБ-аар буюу 47.5 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт

хийх үйлчилгээ 21 ББСБ-аар буюу 95.5 хувиар, факторингийн үйлчилгээ 20 ББСБ-аар буюу 46.5 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 16 ББСБ-аар буюу 43.2 хувиар тус тус өссөн байна.

2024 оны III улирлын тайлан мэдээний ирц 97.7% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 555 ББСБ-аас 542 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 6 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 7 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

## Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

ББСБ-ууд хөрөнгийн зах зээлд гарч, нээлттэй хувьцаат компани болох, банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагааг эрхлэх, олон улсаас хөрөнгө оруулалт татах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр нягтлан бодох бүртгэл, тайлагналыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэх, салбарын нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг шинэчлэх, зайлшгүй шаардлага үүссэн. Үүний дагуу “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/226/528 тоот тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд ББСБ-ууд энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Шинэчилсэн журамд СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС-13 Бодит үнэ цэнийн хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар тусгасан.

### Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2024 оны III улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 95.3 хувь буюу 491 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 87.0 хувь буюу 448 ББСБ хэрэгжүүлсэн байна.

### Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 492 ББСБ-ын 91.1 хувь буюу 448 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 113 ББСБ, 15,770 удаагийн тохиолдлоор, 1.9 их наяд төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 8 ББСБ, 338 удаагийн тохиолдлоор, 3.3 их наяд төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

### “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2024 оны III улирлын байдлаар нийт 516 ББСБ-аас 1,292.98 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 99.2% буюу 510 ББСБ 1,282.3 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

## Статистик үзүүлэлтүүд

2024 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 34,174 хувьцаа эзэмшигчдийн 555 ББСБ, 484 салбар нэгж, 12 төлөөлөгчийн газар, 5,855 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.9 сая харилцагч, 2.0 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

### Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 19.1 хувиар өсөж давхардсан тоогоор 4,932,619-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 36.2 хувиар өсөж 1,990,848-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,932,619	4,411,567	260,952	4,671,667	87,592	4,881,308	51,311	369,028	94,937
Үүнээс: Эмэгтэй	2,692,081	2,408,416	151,046	2,541,035	64,620	2,665,448	26,633	202,690	51,118
Эрэгтэй	2,233,903	2,001,792	104,279	2,129,624	18,733	2,209,296	24,607	165,803	43,503
Хуулийн этгээд	6,654	1,359	5,646	1,008	4,239	6,583	71	535	316
Итгэмжлэгчдийн тоо	13,009	13,007	1,341	11,668	-	12,980	29	7,058	375
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,239	1,189	100	1,139	-	1,239	-	355	-
Зээлдэгчдийн тоо	1,990,848	1,558,215	172,166	1,818,682	-	1,942,886	47,962	208,366	94,936
Хэвийн	1,799,452	1,420,149	148,843	1,650,609	-	1,758,459	40,993	178,593	84,011
Хугацаа хэтэрсэн	55,650	40,478	5,403	50,247	-	53,617	2,033	9,262	2,587
Чанаргүй:	135,746	97,588	17,920	117,826	-	130,810	4,936	20,511	8,338
-Хэвийн бус	37,009	26,517	2,874	34,135	-	35,811	1,198	6,824	2,987
-Эргэлзээтэй	34,983	24,890	2,884	32,099	-	33,455	1,528	6,069	2,624
-Муу	63,754	46,181	12,162	51,592	-	61,544	2,210	7,618	2,727
Зээлдэгчдийн насжилт	1,988,732	1,557,106	170,809	1,817,923	-	1,940,833	47,899	208,041	94,620
18-35 насны	1,216,909	965,577	70,675	1,146,234	-	1,188,185	28,724	122,633	54,774
36-45 насны	508,460	383,726	55,374	453,086	-	496,698	11,762	55,524	24,897
46-55 насны	214,108	169,412	33,902	180,206	-	208,461	5,647	23,342	11,376
55-аас дээш	49,271	38,388	10,874	38,397	-	47,505	1,766	6,542	3,573
Зээлдэгчдийн боловсрол	1,988,732	1,557,106	170,809	1,817,923	-	1,940,833	47,899	208,041	94,620
-Дээд	1,071,591	822,258	86,491	985,100	-	1,048,697	22,894	117,265	61,618
-Тусгай дунд	176,862	138,630	17,224	159,638	-	171,896	4,966	20,428	12,793
-Бүрэн дунд	516,252	409,872	42,990	473,262	-	498,217	18,035	47,250	13,650
-Дунд	171,665	141,226	16,548	155,117	-	170,128	1,537	20,983	4,843
-Бага	52,378	45,117	7,572	44,806	-	51,911	467	2,115	1,716

(Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно)

Нийт харилцагчдын 94.7% буюу 4,671,667 нь, зээлдэгчдийн 91.4% буюу 1,818,682 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 5.3% буюу 260,952 нь, зээлдэгчдийн 8.6% буюу 172,166 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 87,592 буюу нийт харилцагчдын 1.8 хувийг бүрдүүлж байна.

### Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)

Үзүүлэлтүүд	2020-III	2021-III	2022-III	2023-III	2024-III	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,669	21,666	23,143	28,369	34,174	5,805	20.5%
Ажилчдын тоо	3,417	3,820	4,478	4,909	5,855	946	19.3%
Харилцагчдын тоо	2,639,297	4,530,126	4,897,575	4,141,367	4,932,619	791,252	19.1%
Зээлдэгчдийн тоо	551,977	1,562,757	1,644,423	1,461,198	1,990,848	529,650	36.2%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	2.9%	2.6%	3.1%	3.3%	3.4%	+0.1%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 20.5 хувиар буюу 5,805-аар өсөж 34,174-г хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.7 хувь буюу 33,062 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,112 буюу 3.3% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,788 буюу 8.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 223 буюу 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байна. ББСБ-ын салбарын нийт ажилтнуудын тоо өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар буюу 946 ажилтнаар нэмэгдэж 5,855-д хүрсэн байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	34,174	33,284	1,939	32,235	81	33,951	223	33,062	2,788
Нийт ажилтнуудын тоо	5,855	3,555	2,697	3,158	152	5,543	312	494	465
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,409	2,065	1,655	1,754	84	3,207	202	303	287
Эрэгтэй ажилтны тоо	2,446	1,490	1,042	1,404	68	2,336	110	191	178

Хөдөө орон нутгийн 98 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ТЗ-тэй ББСБ-ын тоо</b>	<b>555</b>	<b>90</b>	<b>493</b>	<b>62</b>	<b>60</b>	<b>457</b>	<b>98</b>	<b>5</b>	<b>550</b>	<b>27</b>
1 Зээл	492	90	430	62	-	399	93	5	487	26
2 Факторингийн үйлчилгээ	60	33	39	21	-	56	4	3	57	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	16	21	7	-	27	1	2	26	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	-	6	-	6	-	1	5	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	53	25	31	22	-	50	3	3	50	2
6 Гадаад валютын арилжаа	176	37	150	26	60	160	16	4	172	8
7 Итгэлцлийн үйлчилгээ	90	90	54	36	-	86	4	5	85	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	43	25	27	16	-	41	2	3	40	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

## Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 82.3% буюу 457 ББСБ, салбаруудын 60.2% буюу 291 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 17.7% буюу 98 ББСБ, салбаруудын 39.8% буюу 192 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2024 оны III улирлын байдлаар 111 ББСБ-ын 484 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 57.6 хувийг 13 ББСБ-ын 279 салбар бүрдүүлж байна. Монголын ББСБ-уудаас анх удаа гадаад улсад албан ёсны салбараа нээлээ. Зээл, гадаад валют арилжаа болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 1 ББСБ 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 342 дугаар тушаалаар Австрали улсын Брисбэн хотод салбартай болсон байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	457	291	748	100.0%
1. Сүхбаатар	155	40	195	26.1%
2. Чингэлтэй	126	30	156	20.9%
3. Баянзүрх	52	72	124	16.6%
4. Баянгол	67	38	105	14.0%
5. Хан-Уул	47	40	87	11.6%
6. Сонгинохайрхан	9	59	68	9.1%
7. Багануур	1	7	8	1.1%
8. Налайх	-	5	5	0.7%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	98	192	290	100%
Архангай аймаг	3	7	10	3.5%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.5%
Баянхонгор аймаг	4	8	12	4.3%
Булган аймаг	2	2	4	1.4%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.1%
Говьсүмбэр аймаг	3	4	7	2.5%
Дархан-Уул аймаг	8	13	21	7.4%
Дорноговь аймаг	1	10	11	3.9%
Дорнод аймаг	5	14	19	6.7%
Дундговь аймаг	-	6	6	2.1%
Завхан аймаг	3	5	8	2.8%
Орхон аймаг	12	19	31	11.0%
Өвөрхангай аймаг	11	13	24	8.5%
Өмнөговь аймаг	2	16	18	6.4%
Сүхбаатар аймаг	5	7	12	4.3%
Сэлэнгэ аймаг	8	12	20	7.1%
Төв аймаг	18	6	24	8.5%
Увс аймаг	4	8	12	4.3%
Ховд аймаг	1	7	8	2.8%
Хөвсгөл аймаг	2	10	12	4.3%
Хэнтий аймаг	3	10	13	4.6%

## Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2024 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 6.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 84.2 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Активын үзүүлэлтүүд	2023-III		2024-III		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	4,121,960.6	96.8%	6,151,577.7	95.9%	2,029,617.1	49.2%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	529,286.0	12.4%	726,641.3	11.3%	197,355.3	37.3%
Хөрөнгө оруулалт	41,678.2	1.0%	72,416.4	1.1%	30,738.2	73.8%
Зээл (цэврээр)	3,189,615.7	74.9%	5,155,519.8	80.3%	1,965,904.1	61.6%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	15,223.2	0.4%	17,951.9	0.3%	2,728.7	17.9%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	5,189.3	0.1%	815.0	0.0%	(4,374.3)	-84.3%
Бусад санхүүгийн хөрөнгө	340,968.3	8.0%	178,233.1	2.8%	(162,735.2)	-47.7%
<b>САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	135,395.5	3.2%	266,020.7	4.1%	130,625.2	96.5%
Санхүүгийн бус бусад хөрөнгө			103,290.1	1.6%	103,290.1	-
Үндсэн хөрөнгө (цэврээр)	135,395.4	3.2%	124,482.8	1.9%	(10,912.6)	-8.1%
Биет бус хөрөнгө (цэврээр)			38,247.8	0.6%	38,247.8	-
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,257,356.1</b>	<b>100.0%</b>	<b>6,417,598.3</b>	<b>100%</b>	<b>2,160,242.2</b>	<b>50.7%</b>


2024 оны III улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 10.2 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 14.6 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2019 оны мөн үед 1,628.5 тэрбум төгрөг байсан бол 2024 оны III улирлын байдлаар 3.9 дахин өсөж 6,417.6 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 4.4 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын нийт хөрөнгийн 98.0% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 391 ББСБ, 0.7% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 19 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.3 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 145 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	5,527.9	155	86.1%	27.9%	22.7	3	7.7	1	-	-
2.5-5.0 тэрбум	763.5	236	11.9%	42.5%	3.5	1	14.9	4	5.5	2
1.9-2.5 тэрбум	43.2	19	0.7%	3.4%	-	-	2.2	1	2.1	1
1.4-1.9 тэрбум	18.2	11	0.3%	2.0%	2.9	2	9.9	6	1.8	1
0.6-1.4 тэрбум	31.3	33	0.5%	5.9%	10.9	12	11.4	11	7.8	9
0.6 тэрбум хүртэлх	33.5	101	0.5%	18.2%	-	-	17.1	54	16.4	47
<b>НИЙТ</b>	<b>6,417.6</b>	<b>555</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>40.0</b>	<b>18</b>	<b>63.2</b>	<b>77</b>	<b>33.6</b>	<b>60</b>

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 3.7 их наяд төгрөг байгаа нь нийт активын 57.1 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 3.1 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 58.8 хувийг бүрдүүлж байна.

### Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 197.4 тэрбум төгрөгөөр буюу 37.3 хувиар өсөж 726.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 13.2 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 76.5 хувь нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 10.3% нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	706.7	406.6	362.2	344.4	32.1	687.5	19.2	155.6	162.3
Бэлэн мөнгө	93.7	6.1	88.1	5.6	22.1	85.1	8.6	0.2	3.2
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	556.8	372.8	243.9	313.0	9.5	547.1	9.7	153.6	152.7
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8.2	4.4	4.9	3.3	-	8.1	0.0	0.1	0.1
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	47.9	23.4	25.4	22.6	0.5	47.1	0.9	1.7	6.3

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 24.6%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.3%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 71.4% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



### Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 73.8 хувиар буюу 30.7 тэрбум төгрөгөөр өсөж, 2024 оны III улирлын байдлаар 36 ББСБ 72.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй

гарсан байна. Хөрөнгө оруулалтын 0.3% буюу 248.7 сая төгрөгийг хадгаламжийн сертификат, 99.7% буюу 72.2 тэрбум төгрөгийг үнэт цаасаарх хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлшэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	72,416.4	67,496.8	7,420.0	64,996.5	1.0	71,462.9	953.5	46,073.0	41,276.1
Хадгаламжийн сертификат	248.7	-	248.7	-	-	248.7	-	-	-
Үнэт цаас	72,167.7	67,496.8	7,171.3	64,996.5	1.0	71,214.2	953.5	46,073.0	41,276.1
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	42,906.6	39,034.2	5,114.3	37,792.3	1.0	41,953.2	953.4	20,998.6	20,493.9
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	7,317.3	7,317.3	1,075.0	6,242.3	-	7,317.3	-	4,292.3	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	20,228.6	20,228.6	183.4	20,045.1	-	20,228.6	-	20,045.1	20,045.1
Барьцаанд байгаа үнэт цаас	398.4	-	398.4	-	-	398.4	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,316.9	916.8	400.1	916.8	-	1,316.8	0.1	737.0	737.0
<b>(Үнэт цаасны эрсдэлийн сан)</b>	-	-	-	-	-	-	-	-	-

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөлтэй 43 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 36 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 28 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Бусдаас эх үүсвэр татаж, түүгээрээ зөвшөөрөлгүйгээр богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг эрхэлсэн 8 ББСБ байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

### Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 59.8% буюу 2.0 тэрбум төгрөгөөр өсөж 2024 оны III улирлын байдлаар 5.4 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 244.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 5.2 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	5,155,519.8	3,885,675.7	2,056,331.5	3,099,188.4	1,893.8	5,075,953.5	79,566.4	894,071.7	683,381.6
Зээл	5,400,434.4	4,049,497.2	2,164,807.6	3,235,626.8	1,983.1	5,313,387.6	87,046.8	939,695.0	723,261.1
Хэвийн	4,686,006.5	3,577,447.3	1,833,796.8	2,852,209.7	1,829.5	4,613,793.1	72,213.4	802,843.8	604,624.9
Анхаарал хандуулах	190,002.8	138,867.1	73,922.3	116,080.5	-	187,657.4	2,345.4	52,849.5	45,761.4
Чанаргүй зээл	322,155.8	211,205.0	153,914.4	168,241.3	153.7	312,505.9	9,649.9	53,705.1	48,518.6
-Хэвийн бус зээл	90,105.5	62,974.2	39,180.9	50,924.6	82.6	88,208.8	1,896.7	21,466.9	16,651.1
-Эргэлзээтэй зээл	83,415.5	58,253.0	37,693.6	45,721.9	4.8	81,446.4	1,969.1	20,271.4	17,274.6
-Муу зээл	148,634.8	89,977.9	77,040.0	71,594.8	66.3	142,850.7	5,784.1	11,966.8	14,592.9
<b>(ЗЭС)</b>	244,519.0	163,821.5	108,080.6	136,438.4	89.3	237,038.6	7,480.4	45,623.3	39,483.9
Хойшлогдсон төлбөр	2,572.6	2,559.8	192.1	2,380.5	-	2,572.6	-	2,333.0	2,333.0
Зээлд хур/тооцсон хүүгийн авлага	204,842.0	124,537.6	103,366.2	101,475.7	-	202,003.8	2,838.1	32,629.7	26,689.2
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	395.6	-	395.6	-	-	395.6	-	-	395.6

(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг 1 ББСБ 2.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан ба нэр бүхий 1 ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг

2024.03.20-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна. Тайлант улиралд ББСБ-ууд 8.5 их наяд төгрөгийн зээлийг 3.4 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 7.0 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2024 оны III улирлын байдлаар 2.0 сая зээлдэгчийн 5.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 90.1 хувийг буюу 4.7 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.7 хувийг буюу 190.0 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.2 хувийг буюу 322.2 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)



Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 1.1, 0.1 пунктээр өссөн бол чанаргүй зээлийн хэмжээ 1.3 пунктээр буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 512.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 47.7 хувьд буюу 244.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2024 оны III улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 9.9% байна.

Олгосон зээлийн 93.1% буюу 7.9 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 6.9% буюу 588.9 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 93.1% буюу 6.5 их наяд төгрөг нь иргэдээс, 6.9% нь буюу 483.5 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.


2024 оны III улирлын байдлаар 5.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 89.7 хувь буюу 4.7 их наяд төгрөгийг иргэдийн, 10.3 хувь буюу 535.6 тэрбум төгрөгийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	54,302.2	0.64%	41,694.1	0.6%	61,856.4	1.2%
2.	Уул уурхай, олборлолт	54,124.7	0.6%	40,961.1	0.6%	68,320.0	1.3%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	46,382.3	0.5%	37,783.1	0.5%	45,329.0	0.9%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	9,661.1	0.1%	7,734.2	0.1%	8,432.3	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3,521.6	0.0%	2,138.9	0.0%	3,424.7	0.1%
6.	Барилга	214,493.6	2.5%	170,459.1	2.4%	285,895.6	5.5%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	569,494.3	6.7%	416,360.5	6.0%	538,640.1	10.4%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	137,450.3	1.6%	124,812.0	1.8%	120,537.0	2.3%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	109,402.7	1.3%	112,080.2	1.6%	121,625.3	2.3%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	84,046.4	1.0%	69,648.9	1.0%	126,533.2	2.4%
11.	Мэдээлэл холбоо	9,877.8	0.1%	8,754.5	0.1%	12,802.0	0.2%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	156,381.3	1.8%	131,421.2	1.9%	97,721.1	1.9%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	26,039.9	0.3%	20,433.5	0.3%	35,504.6	0.7%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5,004.8	0.1%	3,950.2	0.1%	5,058.0	0.1%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	19,493.2	0.2%	15,984.6	0.2%	22,499.5	0.4%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	8,838.3	0.1%	3,135.4	0.0%	7,929.6	0.2%
17.	Боловсрол	31,558.6	0.4%	21,796.5	0.3%	26,345.7	0.5%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	20,650.7	0.2%	16,483.0	0.2%	21,295.6	0.4%
19.	Бусад	6,958,335.9	81.7%	5,736,716.0	82.2%	3,588,415.4	69.0%
<i>Иргэнд олгосон зээл</i>		7,930,179.4	93.1%	6,498,836.7	93.1%	4,662,589.4	89.7%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		588,880.4	6.9%	483,510.6	6.9%	535,575.7	10.3%
<b>НИЙТ</b>		<b>8,519,059.8</b>	<b>100.0%</b>	<b>6,982,347.3</b>	<b>100.0%</b>	<b>5,198,165.1</b>	<b>100.0%</b>

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “[Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал](#)”-аар нийт олгосон зээлийн 81.7% буюу 7.0 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглээний зээл), 6.7% буюу 569.5 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 82.2% буюу 5.7 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.0% буюу 416.4 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Тайлант улиралд олгосон 8.5 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 24.5 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 23.2 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 5.2 их наядын зээлийн 58.7 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 27.0 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 8.0 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
<b>Иргэнд олгосон зээл</b>	<b>7,930.2</b>	<b>93.1%</b>	<b>6,498.8</b>	<b>93.1%</b>	<b>4,662.6</b>	<b>89.7%</b>
Хэрэглээнд зориулсан зээл	5,796.1	68.0%	4,699.5	67.3%	3,053.9	58.7%
<i>Үүнээс: Автомашинд зориулсан зээл</i>	<i>1,389.0</i>	<i>16.3%</i>	<i>788.2</i>	<i>11.3%</i>	<i>1,403.0</i>	<i>27.0%</i>
Бизнес зориулсан зээл	976.6	11.5%	853.8	12.2%	886.7	17.1%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	165.2	1.9%	121.6	1.7%	200.0	3.8%
Бусад зээл	992.3	11.6%	823.9	11.8%	522.0	10.0%
<b>Хуулийн этгээдэд олгосон зээл</b>	<b>588.9</b>	<b>6.9%</b>	<b>483.5</b>	<b>6.9%</b>	<b>535.6</b>	<b>10.3%</b>
Бизнесийн зээл	481.1	5.6%	391.0	5.6%	455.2	8.8%
Автомашинны зээл	9.7	0.1%	7.0	0.1%	11.4	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	11.4	0.1%	9.7	0.1%	11.3	0.2%
Бусад зээл	86.6	1.0%	75.9	1.1%	57.6	1.1%
<b>НИЙТ</b>	<b>8,519.1</b>	<b>100.0%</b>	<b>6,982.3</b>	<b>100.0%</b>	<b>5,198.2</b>	<b>100.0%</b>

## Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2024 оны III улирлын байдлаар 62 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	3,953,382,757,182.5	76.1%	436,820	21.9%	9,050,370.3
Цахим зээл	1,244,782,345,635.0	23.9%	1,554,028	78.1%	801,003.8
<b>Нийт</b>	<b>5,198,165,102,817.4</b>	<b>100.0%</b>	<b>1,990,848</b>	<b>100.0%</b>	<b>2,611,030.6</b>

2024 оны III улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1.6 сая зээлдэгчийн 1.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 78.1 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 23.9 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 801.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 11.3 дахин бага байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр)

№	Финтек	App нэр	Бүртгүүлсэн огноо
1	"Инвекор хэтэвч ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.08-№7/1871
2	"Соно финтек ББСБ" ХХК	Sono Mongolia	2023.03.03-№7/895
3	"Кэйш флов финанс ББСБ" ХХК	Tugrug App	2024.02.21-№7/632
4	"Анлок капитал ББСБ" ХХК	Unlock Finance	2024.04.23-№7/1442
5	"Мобифинанс ББСБ" ХХК	Monpay	2023.06.20-№7/2540
6	"ТОКИ ББСБ" ХХК	Toki	2023.06.20-№7/2549
7	"Лэндмн ББСБ" ХХК	LendMN	2023.06.20-№7/2550
8	"Ньюстар финанс ББСБ" ХХК	Lite+ Nsf.mn	2023.06.20-№7/2553 2023.06.20-№7/2552
9	"Цогзолфинанс ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.23-нд мэдэгдсэн.
10	"Сэндли ББСБ" ХХК	Sendly	2023.07.04-№7/2821
11	"Хатан суудал инвест ББСБ" ХХК	Zeely	2023.03.03-№7/894
12	"Соломон инвестментс ББСБ" ХХК	M credit	2023.11.10-№7/4319
13	"Нөмөр кредит ББСБ" ХХК	Numur	2023.03.03-№7/890
14	"Дэвжих нэхий ББСБ" ХХК	Money-T	2023.12.22-№7/4870
15	"Сэнд эм эн ББСБ" ХХК	SendMN Pocket.mn	2024.02.21-№7/636 2023.12.20-нд мэдэгдсэн.
16	"Төвхөн ингүүмэл ББСБ" ХХК	Oneclick.mn	2024.07.09-№7/2534
17	"Ардкредит ББСБ" ХХК	Ard	2023.12.22-№7/4873
18	"Ашид капитал ББСБ" ХХК	Simple.mn	2023.11.10-№7/4317
19	"Гэрэлфинанс ББСБ" ХХК	Gerel	2023.05.08-№7/1872
20	"Таван богд финанс ББСБ" ХХК	PayOn.mn	2023.07.04-№7/2826
21	"Энт кредит инвестмент ББСБ" ХХК	EntCreditMN	2023.03.03-№7/891
22	"Мөнгөнзоос кредит ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.24-нд мэдэгдсэн.
23	"Си И Си инвестмент ББСБ" ХХК	Pocket.mn	2024.04.24-нд мэдэгдсэн.
24	"Инвекор ББСБ" ХХК	InvesCore Pocket.mn	2023.08.25-№7/3350 2023.05.25-нд мэдэгдсэн.
25	"Грийн-Инвестмент ББСБ" ХХК	Gate.mn	2023.07.04-№7/2827
26	"Өсөх ундарга финанс ББСБ" ХХК	Ufinance	2024.09.23-№7/3171
27	"Их Монгол кредит ББСБ" ХХК	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
28	"Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК	BiD	2023.08.25-№7/3353
29	"Очир ундраа ОМЗ ББСБ" ХХК	Opay MN	2023.08.25-№7/3351
30	"Есөн финанс ББСБ" ХХК	MetaLend	2023.08.25-№7/3352
31	"Нэт капитал финанс корпораци ББСБ" ХХК	NetPay	2023.07.04-№7/2825
32	"Инвеско фонд ББСБ" ХХК	IF.mn	2023.08.25-№7/3349
33	"Жи би си си ББСБ" ХХК	E-zeel	2023.03.03-№7/889
34	"Нанокпитал ББСБ" ХХК	Nano Capital	2023.07.04-№7/2824
35	"Алтан зоос капитал ББСБ" ХХК	ZOOS	2024.05.30-№7/2046
36	"Хас хаан ББСБ" ХХК	XACXAAH	2023.06.20-№7/2551
37	"Изи пэй норбула ББСБ" ХХК	Easypay.mn	2023.12.22-№7/4867
38	"Девелопинг энтрепнориал монголиа ББСБ" ХХК	DEM.mn	2024.05.30-№7/2045
39	"Гурван зуун жар финанс ББСБ" ХХК	Minu pay	2023.07.04-№7/2822
40	"Монголиа импакт финанс ББСБ" ХХК	Qmoni	2023.08.25-№7/3356

41	"Эс ай си эй финанс ББСБ" ХХК	Khanguud	2023.12.22-№7/4872
42	"Микрокредит ББСБ" ХХК	Easy	2023.12.22-№7/4871
43	"Магна профит энд инвестмент ББСБ" ХХК	Magna.mn	2024.02.21-№7/635
44	"Онч-Энх ББСБ" ХХК	Ugloo	2023.03.30-№7/1297
45	"Говьфинанс ББСБ" ХХК	CashOne	2023.08.25-№7/3354
46	"Гоулдман инвестмент групп ББСБ" ХХК	Goldpay	2023.08.25-№7/3355
47	"Дарь финанс ББСБ" ХХК	Pocket.mn	2024.03.01-нд мэдэгдсэн.
48	"Есөн эрдэнэ финанс ББСБ" ХХК	Leasing.mn	2023.03.30-№7/1298
49	"Жи Эс Би капитал ББСБ" ХХК	Prime	2024.02.21-№7/631
50	"Зээл Эм Эн платформ ББСБ" ХХК	Zeel.mn	2023.07.04-№7/2828
51	"Их ирээдүй капитал ББСБ" ХХК	Easy loan	2024.05.30-№7/2043
52	"Монкор финанс ББСБ" ХХК	T-Friend	2024.07.09-№7/2535
53	"Номин юнити ББСБ" ХХК	OmniWay Nomin Unity	2024.02.21-№7/634 2024.04.23-№7/1443
54	"Омни капитал ББСБ" ХХК	Moni	2023.07.05-№7/2869
55	"Прогресс финтек ББСБ" ХХК	Zuut	2024.05.30-№7/2044
56	"Тапапэй ББСБ" ХХК	Tapatrip	2024.09.24-№7/3174
57	"Тус финтек ББСБ" ХХК	Tus fintech	2023.05.19-№7/2125
58	"Финко капитал ББСБ" ХХК	Beep	2024.09.23-№7/3172
59	"Финрүүт-инвестмент ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.24-нд мэдэгдсэн.
60	"Франкфурт капитал ББСБ" ХХК	Nar app	2023.07.04-№7/2823
61	"Централ капитал ББСБ" ХХК	Kmobimn	2024.04.23-№7/1441
62	"Эм Эл Жи финанс Юү Би ББСБ" ХХК	ANDA	2024.07.09-№7/2536

*/"Инвекор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 8 ББСБ байна.  
Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 5 ББСБ-ыг шаарар тэмдэглэв/*

2024 оны III улирлын байдлаар [“Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”](#)-д заасан шаардлагыг хангаж Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн 62 ББСБ байна.

## Ногоон зээл

Тайлант хугацаанд 27 ББСБ 2,404 зээлдэгчид 56.7 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.6 хувийн хүүтэйгээр олгож, 29 ББСБ-ын 5,703 зээлдэгчээс 58.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2024 оны III улирлын байдлаар 33 ББСБ 6,386 зээлдэгчийн 126.4 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.4%-тай тэнцэж байна.


Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 12 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	223.0	109	71.2	119	246.6	132
2. Эрчим хүчний үр ашиг	663.1	28	200.3	50	685.9	57
3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	6,306.6	305	3,807.1	210	11,924.5	825
4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	22.5	1	1,824.1	17	11,577.0	138
5. Тогтвортой ус, хог хаягдал	-	-	-	-	-	-
6. Тогтвортой хөдөө аж, ахуй	300.0	1	77.2	68	6,033.4	514
7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	450.6	4	241.4	4	919.9	5
8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	45,797.3	1,951	51,656.8	5,235	82,244.9	4,707
8.1.Цахилгаан тээврийн хэрэгсэл	5,578.5	249	353.8	20	5,599.2	3
8.2.Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл	37,018.8	1,701	51,205.6	5,215	71,815.0	4,704
8.3.Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл	-	-	-	-	-	-
8.4.Дугуй, скүүтэр	-	-	-	-	-	-
8.5.Бусад	3,200.0	1	97.4	-	4,830.7	-
9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	-	-	-	-	-	-
10. Эрүүл мэнд	600.0	2	115.6	-	727.5	3
11. Боловсрол, Соёл	2,330.5	3	181.2	-	2,149.3	3
12. Хүртээмжтэй дэд бүтэц	-	-	21.9	-	9,855.1	2
<b>НИЙТ</b>	<b>56,693.6</b>	<b>2,404</b>	<b>58,196.6</b>	<b>5,703</b>	<b>126,364.0</b>	<b>6,386</b>

Ногоон зээлийн үлдэгдлийн 65.1% буюу 82.2 тэрбум төгрөгийг нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээврийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 9.2% буюу 11.6 тэрбум төгрөгийг бохирдлыг бууруулах ба сэргийлэх салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 9.4% буюу 11.9 тэрбум төгрөгийг тогтвортой хот төлөвлөлт ба барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тогтвортой ус, хог хаягдал болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарт зээлийн үлдэгдэлгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 88.2% нь хэвийн, 8.0% нь анхаарал хандуулах, 3.8% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба хүртээмжтэй дэд бүтэц салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 26.0% нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)



## Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 19.8 хувиар буюу 3.0 тэрбум төгрөгөөр өсөж, 19 ББСБ 18.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2024 оны III улирлын байдлаар 905.6 сая төгрөгийн факторингийн тооцооны хүүгийн авлага хуримтлуулан бүртгэсэн байна. Нийт 983.4 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 466.8 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 18.4 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)

Нийт факторингийн тооцооны авлага	2023-III		2024-III		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь		
	15,370.7	100.0%	18,418.7	100.0%	3,048.1	19.8%
Хэвийн	14,802.8	96.3%	16,529.7	89.7%	1,726.9	11.7%
Анхаарал хандуулах	180.7	1.2%	213.4	1.2%	32.7	18.1%
Чанаргүй	387.2	2.5%	770.0	4.2%	382.8	2.0
Хэвийн бус	285.0	1.9%	314.3	1.7%	29.3	10.3%
Эргэлзээтэй	70.0	0.5%	156.1	0.8%	86.1	2.2
Муу	32.2	0.1%	299.5	1.6%	267.3	9.3
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	147.5	0.1%	466.8	2.5%	319.4	3.2
Факторингийн тооцооны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	0.1%	905.6	4.9%	905.6	-

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй 60 ББСБ-уудын 41 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь тул холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө

2024 оны III улирлын байдлаарх 1 ББСБ 815.0 сая төгрөгийн своп арилжаа хийсэн байна.

Бусад санхүүгийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 47.7 хувь буюу 162.7 тэрбум төгрөгөөр буурч 178.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>Үүсмэл санхүүгийн хөрөнгө</b>	815.0	815.0	815.0	-	-	815.0	-	-	-
Своп арилжаа	815.0	815.0	815.0	-	-	815.0	-	-	-
<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	178,233.1	134,720.9	56,885.3	121,347.8	395.5	176,299.5	1,933.6	65,895.5	58,568.4
Авлага (цэвэр дүнгээр)	159,919.9	121,185.2	50,097.2	109,822.7	386.5	158,204.6	1,715.3	65,865.7	58,300.9
Салбар хоорондын тооцоо	4,515.3	4,385.4	30.6	4,484.7	-	4,515.3	-	29.8	-
Өмчлөх бусад хөрөнгө – санхүүгийн хөрөнгө (цэвэр дүнгээр)	7,226.3	6,419.4	1,786.5	5,439.8	-	7,226.3	-	-	-
Бусад	6,571.6	2,730.9	4,971.0	1,600.6	9.0	6,353.2	218.4	-	267.6

## Санхүүгийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2024 оны III улирлын байдлаар 174.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 50.1 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, 69.8 тэрбум төгрөгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэсэн байгаа бол 59.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 21.5 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Ингэснээр тайлант хугацаанд 124.0 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 42.9 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

*Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)*

Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
	<b>162,730.6</b>	<b>111,953.5</b>	<b>63,085.4</b>	<b>99,645.2</b>	<b>779.3</b>	<b>159,215.9</b>	<b>3,514.7</b>	<b>25,473.1</b>	<b>21,904.2</b>
<b>Үндсэн хөрөнгө (цэврээр)</b>	<b>124,020.7</b>	<b>80,380.9</b>	<b>56,817.5</b>	<b>67,203.2</b>	<b>493.3</b>	<b>121,097.0</b>	<b>2,923.7</b>	<b>12,410.2</b>	<b>14,458.4</b>
Барилга, байгууламж	54,510.0	42,032.6	19,240.6	35,269.4	83.1	53,225.3	1,284.7	4,085.5	5,977.8
Компьютер, дагалдах хэрэгсэл	9,678.3	6,189.2	4,432.9	5,245.4	28.5	9,298.6	379.8	1,351.1	1,488.0
Тээврийн хэрэгсэл	33,834.0	12,893.0	24,489.0	9,345.0	300.0	33,220.2	613.7	612.4	1,589.2
Тавилга, эд хогшил	14,023.5	9,399.6	6,353.2	7,670.3	76.8	13,646.3	377.2	1,414.9	1,623.5
Түрээсийн хөрөнгө	8,551.1	8,473.5	77.6	8,473.5	-	8,540.3	10.8	4,937.7	3,777.7
Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	3,423.9	1,393.0	2,224.2	1,199.6	4.9	3,166.3	257.6	8.6	2.2
<b>Биет бус хөрөнгө (цэврээр)</b>	<b>42,900.6</b>	<b>35,385.3</b>	<b>4,994.3</b>	<b>37,906.3</b>	<b>8.9</b>	<b>42,666.1</b>	<b>234.5</b>	<b>19,847.9</b>	<b>5,046.5</b>
Зохиогчийн эрх	3.1	1.5	3.1	-	-	1.5	1.6	-	-
Програм хангамж	29,158.5	23,903.7	1,755.5	27,403.1	8.9	28,925.7	232.9	14,180.2	5,044.9
Мэдээллийн сан	-	-	-	-	-	-	-	-	-
Патент	10.2	-	10.2	-	-	10.2	-	-	-
Барааны тэмдэг	10.0	10.0	-	10.0	-	10.0	-	-	-
Тусгай зөвшөөрөл	8.7	-	-	8.7	-	8.7	-	-	-
Газар эзэмших эрх	858.4	733.4	418.9	439.4	-	858.4	-	-	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	4,552.5	4,532.1	566.3	3,986.2	-	4,552.5	-	56.9	-
Бусад биет бус хөрөнгө	8,299.1	6,204.7	2,240.3	6,058.9	-	8,299.1	-	5,610.9	1.6

## Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 63.4 хувийг өр төлбөрийн өсөлт, 36.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:


Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Пассивын үзүүлэлтүүд	2023-III	Нийт дүнд	2024-III	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	1,667,723.1	39.2%	3,038,317.5	47.3%	1,370,594.4	82.2%
<b>САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	1,335,664.5	31.4%	2,866,470.3	44.7%	1,530,805.8	114.6%
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	519,346.5	12.2%	1,062,760.9	16.6%	543,414.4	104.6%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	470,565.3	11.1%	1,026,257.7	16.0%	555,692.4	118.1%
Бусад эх үүсвэр	345,752.7	8.1%	543,000.4	8.5%	197,247.7	57.0%
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	-	-	1,151.6	0.0%		
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	232,876.9	3.6%		
Хоёрдогч өглөг	-	-	422.9	0.0%		
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	0.0	0.0%		
<b>САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	332,058.6	7.8%	171,847.2	2.7%	(160,211.4)	-48.2%
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,589,633.0	60.8%	3,379,280.8	52.7%	789,647.8	30.5%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,453,045.0	34.1%	1,714,924.3	26.7%	261,879.3	18.0%
Нэмж төлөгдсөн капитал	-	-	85,716.8	1.3%		
Халаасны хувьцаа	-	-	2,580.2	0.0%		
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	5,243.6	0.1%	
Хуримтлагдсан ашиг, алдагдал	994,795.6	23.4%	1,501,679.6	23.4%	506,884.0	51.0%
Бусад өмч	141,792.4	3.3%	74,296.7	1.2%	(67,495.7)	-47.6%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	4,257,356.1	100.0%	6,417,598.3	100.0%	2,160,242.2	50.7%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 2.0 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 2.2 дахин, бусад эх үүсвэр 57.0 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 51.0 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 18.0 хувиар тус тус өссөн байна.


Салбарын сүүлийн 5 жилийн байдлаарх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2019 оны мөн үед өөрийн хөрөнгө банкны салбарын 38.8 хувьд хүрдэг байсан бол 2024 оны III улирлын байдлаар 52.1 хувьд хүрч байна. 2024 оны III улирлын байдлаар 555 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны 12 банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 99.4 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 37.4 хувьтай тэнцдэг байсан бол 2024 оны III улирлаар 2.2 пунктээр өсөж 39.7 хувьтай тэнцэж байна.

Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2024 оны III улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2019 оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өсөж 3.4 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.1 дахин өсөж 3.0 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



### Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2024 оны III улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буюу 543.4 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 90 ББСБ-аас 81 ББСБ 13,009 итгэмжлэгчээс 1,062.8 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)



Нийт татан төвлөрүүлсэн итгэлцлийн өглөгийн 67.9 хувийг иргэдээс, 31.6 хувийг хувийн байгууллагаас, 0.5 хувийг өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)-аас, 0.1 хувийг эдийн засгийн харьяат бус этгээдээс татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1.0 их наяд төгрөгийг татан төвлөрүүлж үүнд 45.7 тэрбум төгрөгийн үр шим хуримтлуулан тооцож бүртгэсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)

	Дүн	Хувь	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,062,760.9	-	1,062,246.1	208,325.0	854,435.8	1,058,671.0	4,089.9	277,460.8	189,123.4
Хувийн байгууллага	321,202.9	30.2%	320,688.1	80,755.2	240,447.6	318,701.5	2,501.4	38,064.2	34,402.3
Иргэд	690,596.3	65.0%	690,596.3	112,493.7	578,102.6	689,179.7	1,416.6	225,437.3	140,792.8
Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	4,994.1	0.5%	4,994.1	4,994.1	-	4,994.1	-	-	3,502.4
Эдийн засгийн харьяат бус	683.8	0.1%	683.8	-	683.8	683.8	-	683.8	-
Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлууулж тооцсон үр шим	45,659.3	4.3%	45,659.3	10,082.0	35,577.3	45,487.4	171.9	13,650.9	10,425.8
Итгэлцлээр татсан хөрөнгийн хойшлогдсон төлбөр	(375.5)	-0.04%	375.5	-	375.5	375.5	-	375.5	-
Нийт итгэмжлэгчдийн тоо	13,009		13,007	1,341	11,668	12,980	29	7,058	375

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

2024 оны III улирлын байдлаар өр төлбөрөөс хамгийн өндөр өсөлтийг дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 2.2 дахин өсөж, 119 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 1,026.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	<b>1,026,257.7</b>	<b>922,079.6</b>	<b>289,412.5</b>	<b>736,845.2</b>	<b>768.1</b>	<b>1,023,136.9</b>	<b>3,120.8</b>	<b>408,268.7</b>	<b>323,359.5</b>
<b>Авсан зээл</b>	<b>999,058.9</b>	<b>898,150.8</b>	<b>283,725.9</b>	<b>715,333.0</b>	<b>768.1</b>	<b>996,021.4</b>	<b>3,037.5</b>	<b>398,237.3</b>	<b>316,994.6</b>
Дотоодын	535,425.2	474,416.8	127,851.9	407,573.3	261.9	533,852.7	1,572.5	231,745.3	184,650.3
Гадаадын	208,985.2	207,680.4	23,527.1	185,458.1	-	208,985.2	-	131,841.2	132,344.4
Бусад	254,648.5	216,053.6	132,347.0	122,301.5	506.1	253,183.5	1,465.0	34,650.8	-
<b>Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн залруулга</b>									
<b>Хугацаа хэтрэлт</b>	<b>72.8</b>	<b>72.8</b>	<b>-</b>	<b>72.8</b>	<b>-</b>	<b>72.8</b>	<b>-</b>	<b>72.8</b>	<b>-</b>
Дотоодын	72.8	72.8	-	72.8	-	72.8	-	72.8	-
Гадаадын	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн залруулга</b>									
<b>Хойшлогдсон төлбөр</b>	<b>26.5</b>	<b>26.5</b>	<b>-</b>	<b>26.5</b>	<b>-</b>	<b>26.5</b>	<b>-</b>	<b>26.5</b>	<b>-</b>
Дотоодын	23.5	23.5	-	23.5	-	23.5	-	23.5	-
Гадаадын	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	3.0	3.0	-	3.0	-	3.0	-	3.0	-
<b>Хуримтлууулж тооцсон хүүгийн өглөг</b>	<b>27,152.5</b>	<b>23,882.4</b>	<b>5,686.5</b>	<b>21,466.0</b>	<b>-</b>	<b>27,069.1</b>	<b>83.4</b>	<b>9,985.0</b>	<b>6,364.9</b>
Дотоодын	6,193.1	4,524.9	400.7	5,792.4	-	6,192.3	0.8	3,495.0	2,694.0
Гадаадын	4,882.5	4,635.3	567.2	4,315.3	-	4,882.5	-	3,423.8	3,670.9
Бусад	16,076.9	14,722.2	4,718.6	11,358.3	-	15,994.4	82.6	3,066.2	-

Бусад эх үүсвэр

2024 оны III улирлын байдлаар 55 ББСБ 543.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс давхардсан тоогоор 46 ББСБ 498.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг, 7 ББСБ 19.8 тэрбум төгрөгийн төслийн зээлийн санхүүжилт, 7 ББСБ 11.8 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэр, 35 ББСБ 13.3 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрт хуримтлууулж тооцсон хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>Бусад эх үүсвэр</b>	<b>543,000.4</b>	<b>493,673.3</b>	<b>111,519.2</b>	<b>431,481.2</b>	<b>-</b>	<b>543,000.4</b>	<b>-</b>	<b>115,130.7</b>	<b>83,745.3</b>
Гаргасан өрийн бичиг	498,064.1	460,560.7	93,280.0	404,784.1	-	498,064.1	-	113,153.3	73,200.0
Гаргасан үнэт цаас	-	-	-	-	-	-	-	-	-
Төслийн зээлийн санхүүжилт	19,823.1	9,294.0	14,791.9	5,031.3	-	19,823.1	-	-	9,105.5
Бусад	11,794.3	11,762.8	587.5	11,206.8	-	11,794.3	-	-	-

Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	13,318.9	12,055.8	2,859.9	10,459.0	-	13,318.9	-	1,977.3	1,439.8

### ББСБ-аас гаргасан өрийн бичиг


ББСБ-ууд бонд гаргахдаа ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

Тайлант улиралд Биржийн бус зах зээлээс ирүүлсэн тоо мэдээгээр 2024 оны III улирлын байдлаар 42 ББСБ 461,953.0 сая төгрөг татан төвлөрүүлсэн тухай тоо мэдээ ирүүлсэн байна. Үүнийг санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээтэй тулган баталгаажуулахад 5 ББСБ огт бүртгэлгүй санхүүгийн тайланд 20.5 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэл тусгасан байгаа тул журам зөрчсөн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Биржийн бус зах зээлийн тоо мэдээнээс санхүүгийн тайланд тайлагнасан дүн зөрсөн 10 ББСБ байна. Үүнээс 5 ББСБ 30.2 тэрбум төгрөг дутуу тайлагнасан бол 6 ББСБ 73.9 тэрбум төгрөгийг илүү тайлагнасан буюу зөвшөөрөлгүйгээр эх үүсвэр татан төвлөрүүлж тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

46 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд 498.1 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй гаргасан байгаа нь 2019 оны мөн үеэс 12.2 дахин өссөн үзүүлэлт юм.


Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



### Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 7 ББСБ 19.8 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төслийн зээлийн санхүүжилт өмнөх 2019 оны мөн үеэс 1.7 тэрбум төгрөг буюу 9.5 хувиар өссөн байна.

Зураг 12 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Төслийн зээлийн санхүүжилтийг олгосон субьектээр нь ангилж харвал 26.8 хувь нь бусад эх үүсвэрийн, 46.2 хувь нь гадаадын төслийн, 26.9 хувь нь дотоодын санхүүжилттэй төслөөс авсан санхүүжилтийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>Төслийн зээлийн санхүүжилт</b>	<b>19,823.1</b>	<b>9,294.0</b>	<b>14,791.9</b>	<b>5,031.3</b>	-	<b>19,823.1</b>	-	-	<b>9,105.5</b>
Засгийн газрын санхүүжилттэй	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын санхүүжилттэй	9,160.0	9,105.5	9,160.0	-	-	9,160.0	-	-	9,105.5
Дотоодын санхүүжилттэй	5,341.3	188.5	5,341.3	-	-	5,341.3	-	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн санхүүжилтийн зээл	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	5,321.7	-	290.5	5,031.3	-	5,321.7	-	-	-
Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн тохируулга	-	-	-	-	-	-	-	-	-

### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

2024 оны III улирлын байдлаар ББСБ-уудын гаргасан ХБҮЦ-ыг харвал 18-24 сарын хугацаатай, жилийн 17.0-19.6 хувийн хүүтэйгээр, 4.85-50.0 тэрбум төгрөгийг буюу нийт 160.0 тэрбум төгрөгийн 7 ББСБ нээлттэй зах зээлд гаргах зөвшөөрөл авсан байна.

### Бусад санхүүгийн өр төлбөр

2024 оны III улирлын байдлаар 2 ББСБ 1.1 тэрбум төгрөгийн үүсмэл санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 98 ББСБ 232.9 тэрбум төгрөгийн бусад санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 3 ББСБ 422.9 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>Үүсмэл санхүүгийн өр төлбөр</b>	<b>1,151.6</b>	<b>1,151.6</b>	<b>189.6</b>	<b>962.0</b>	-	<b>1,151.6</b>	-	<b>962.0</b>	<b>962.0</b>
Форвард арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Своп арилжаа	1,151.6	1,151.6	189.6	962.0	-	1,151.6	-	962.0	962.0
Опшин арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Фьючерс арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	232,876.9	165,422.3	73,876.7	159,000.1	636.6	230,770.2	2,106.7	79,489.6	57,603.7
Хоёрдогч өглөг	422.9	422.9	300.0	122.9	-	422.9	-	-	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн бус өр төлбөр

Санхүүгийн бус өр төлбөрийн 58.7 хувийг бусад өр төлбөр, 26.8 хувийг тайлант үеийн орлогын албан татварын өглөг, 8.3 хувийг бусад татварын өглөг, 2.3 хувийг цалингийн өглөг, 4.0 хувийг бусад өглөг бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр)

<b>САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>Дүн</b>	<b>Итгэлцэл-тэй</b>	<b>Уламж-лалт</b>	<b>Финтек</b>	<b>ЗГВ</b>	<b>УБ</b>	<b>ХОН</b>	<b>ХК</b>	<b>ГХО</b>
	<b>171,847.2</b>	<b>101,009.0</b>	<b>49,882.8</b>	<b>121,964.3</b>	<b>117.5</b>	<b>170,377.6</b>	<b>1,469.5</b>	<b>13,812.9</b>	<b>8,187.8</b>
Цалингийн өглөг	3,892.1	3,198.3	909.7	2,982.4	22.0	3,856.7	35.4	1,591.2	1,442.5
ЭМ, НДШ-ийн өглөг	1,277.2	399.7	839.5	437.7	14.5	1,226.7	50.4	22.6	66.1
Тайлант үеийн орлогын албан татварын өглөг	45,997.6	37,857.2	13,113.6	32,884.0	20.0	45,609.6	388.0	8,478.8	3,818.7
Бусад татварын өглөг	14,263.8	10,669.2	6,640.3	7,623.5	57.9	14,138.0	125.8	279.3	416.0
Хойшлогдсон татварын өглөг	2,513.4	2,407.4	1,345.1	1,168.3	-	2,501.1	12.3	1,025.5	186.4
Хойшлогдсон орлого	1,338.2	1,333.2	1,188.7	149.5	-	1,338.2	-	-	-
Урьдчилж орсон орлого	1,349.7	763.9	626.2	723.5	-	1,341.4	8,259.6	578.8	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр	20.0	20.0	-	20.0	-	20.0	-	-	-
Бусад	100,938.5	44,360.1	24,963.2	75,975.3	3.2	100,089.1	849.4	1,836.7	2,258.1
Нөөц, болзошгүй өр төлбөр	299.8	-	299.6	0.2	-	299.8	-	-	-

## Өөрийн хөрөнгө

ББСБ-уудын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар буюу 789.6 тэрбум төгрөгөөр өсөж 3.4 их наяд төгрөгт хүрсэн нь нийт активын 52.7 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын өөрийн хөрөнгийн 50.7 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 44.4 хувийг хуримтлагдсан ашиг, 4.9 хувийг өөрийн хөрөнгийн бусад хэсэг бүрдүүлж байна.

Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэл-цэлтэй	Уламж-лалт	Фин-тек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,714.9	713.3	1,174.7	540.2	25.2	1,654.2	60.7	56.6	147.1
Нэмж төлөгдсөн капитал	85.7	85.5	18.2	67.5	0.057	85.7	0.0	68.6	49.0
<b>Халаасны хувьцаа</b>	<b>2.6</b>	<b>2.6</b>	<b>0.2</b>	<b>2.4</b>	<b>-</b>	<b>2.6</b>	<b>-</b>	<b>2.4</b>	<b>0.004</b>
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5.2	1.5	2.3	2.9	-	5.1	0.1	-	0.002
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,501.7	1,088.4	698.9	802.7	6.9	1,470.4	31.3	191.0	132.5
Бусад өмч	74.3	72.3	3.4	70.9	0.0	73.4	0.9	5.8	2.1
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,379.3</b>	<b>1,958.5</b>	<b>1,897.4</b>	<b>1,481.9</b>	<b>32.1</b>	<b>3,286.1</b>	<b>93.2</b>	<b>319.6</b>	<b>330.7</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,417.6</b>	<b>4,704.5</b>	<b>2,630.9</b>	<b>3,786.7</b>	<b>33.6</b>	<b>6,313.6</b>	<b>104.0</b>	<b>1,214.7</b>	<b>993.6</b>
Нийт хөрөнгөд эзлэх хувь	52.7%	41.6%	72.1%	39.1%	95.5%	52.0%	89.6%	26.3%	33.3%

## Хувь нийлүүлсэн хөрөнгө


Хувь нийлүүлсэн хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс 18.0 хувь буюу 261.9 тэрбум төгрөгөөр өсөж 1.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,714,924.3	713,327.5	1,174,710.2	540,214.1	25,163.5	1,654,184.6	60,739.7	56,612.5	147,123.9
Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө)	14,205.3	14,042.0	205.3	14,000.0	-	14,163.0	42.3	12,000.0	12,121.0
Энгийн хувьцаа - Хаалттай	1,656,106.6	654,673.1	1,169,904.9	486,201.6	25,163.5	1,595,409.2	60,697.4	-	113,209.0
Энгийн хувьцаа - Нээлттэй	44,612.5	44,612.5	4,600.0	40,012.5	-	44,612.5	-	44,612.5	21,794.0
Хоёрдогч өглөг (өөрийн хөрөнгө)	74,755.8	74,305.8	450.0	74,305.8	-	74,755.8	-	10,015.4	2,170.4
Хөрвөх өр төлбөр (өөрийн хөрөнгө)	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	85,716.8	85,524.6	18,213.5	67,503.3	56.8	85,667.9	48.9	68,591.4	48,979.1
Давуу эрхийн хувьцаа	5.0	-	5.0	-	-	5.0	-	-	-
Энгийн хувьцаа	85,711.8	85,524.6	18,208.5	67,503.3	56.8	85,662.9	48.9	68,591.4	48,979.1
Халаасны хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6
Давуу эрхийн хувьцаа	-	-	-	-	-	-	-	-	-
Энгийн хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6

2024 оны III улирлын байдлаар 555 ББСБ-ын 1.7 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 14.2 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.6 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 13 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ 1.3 их наяд төгрөг байгаа нь нийт өөрийн хөрөнгийн 39.5 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 2.3 их наяд төгрөг байгаа нийт дүнгийн 76.7 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын үйл ажиллагаа өргөжиж, томрохын хэрээр бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нь нэмэгдэж байгаа тул эдгээр ББСБ-уудын зайны болон газар дээрх хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	624.1	47	36.4%	8.5%	7.3	1	5.6	1	-	-
2.5-5.0 тэрбум	1,025.6	357	59.8%	64.3%	5.8	2	2.5	1	-	-
1.9-2.5 тэрбум	5.8	3	0.3%	0.5%	-	-	1.9	1	3.9	2
1.4-1.9 тэрбум	7.0	5	0.4%	0.9%	2.8	2	2.8	2	1.4	1
0.6-1.4 тэрбум	20.2	25	1.2%	4.5%	9.3	13	7.1	8	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	32.1	118	1.9%	21.3%	-	-	15.1	64	17.0	54
<b>НИЙТ</b>	<b>1,714.9</b>	<b>555</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>25.1</b>	<b>18</b>	<b>35.0</b>	<b>77</b>	<b>25.2</b>	<b>60</b>

1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 407 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.5% буюу 1.7 их наяд төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 148 ББСБ-ын 59.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.5 хувийг бүрдүүлж байна.

### Өөрийн хөрөнгийн бусад хэсэг

2024 оны III улирлын байдлаар 35 ББСБ 5.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 44 ББСБ 74.3 тэрбум төгрөгийн бусад өмчийн үлдэгдэлтэй гарчээ.


Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,243.6	1,464.9	2,332.8	2,910.8	-	5,109.5	134.1	-	1.8
Бусад өмч	74,296.7	72,333.8	3,383.0	70,913.6	17.3	73,357.0	939.6	5,808.8	2,054.6

### Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 51.0% буюу 506.9 тэрбум төгрөгөөр өсөж 1.5 их наяд төгрөгт хүрчээ.


Хүснэгт 34 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд 481 ББСБ нийт 508.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 12 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 62 ББСБ 8.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан 62 ББСБ дотор эх үүсвэр татан төвлөрүүлсэн 4 ББСБ байна. Эдгээрийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг яаралтай хийж гүйцэтгэх шаардлагатай.


Хүснэгт 35 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



## Ашигт ажиллагаа

2024 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 1.3 их наяд төгрөгийн орлого олж, 783.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 499.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 14 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 57.4% буюу 467.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 52.9% буюу 271.0 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 65.1% буюу 196.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 36 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл	2023-III	2024-III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>814,671.4</b>	<b>1,282,617.9</b>	<b>100.0%</b>	<b>467,946.5</b>	<b>57.4%</b>
Хүүгийн орлого	694,330.5	1,117,034.7	87.1%	422,704.3	60.9%
Хүүгийн бус орлого	102,696.4	143,644.2	11.2%	40,947.8	39.9%
Бусад орлого, олз	17,368.4	22,971.5	1.8%	5,603.1	32.3%
Ердийн бус орлого	276.1	-	0.0%	(276.1)	-100.0%
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>512,263.9</b>	<b>783,286.3</b>	<b>100.0%</b>	<b>271,022.3</b>	<b>52.9%</b>
Хүүгийн зардал	98,250.1	273,290.5	34.9%	175,040.4	178.2%
Хүүгийн бус зардал	292,744.3	322,846.7	41.2%	30,102.4	10.3%
Эрсдэлийн сангийн зардал	69,237.5	85,869.5	11.0%	16,631.9	24.0%
Бусад зардал, гарз	7,230.3	12,002.9	1.5%	4,772.6	66.0%
Орлогын албан татварын зардал	44,779.1	89,276.7	11.4%	44,497.6	99.4%
Ердийн бус зардал	22.6	-	0.0%	(22.6)	-100.0%
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>302,407.5</b>	<b>499,331.7</b>	<b>0.0%</b>	<b>196,924.2</b>	<b>65.1%</b>

Нийт орлогын 87.1 хувийг хүүгийн орлого, нийт зардлын 41.2 хувийг хүүгийн бус зардал, 34.9 хувийг хүүгийн зардал бүрдүүлж байна. Хүүгийн бус зардлын 88.1 хувийг үйл ажиллагааны бусад зардал бүрдүүлж байгаа бөгөөд үүний 40.4 хувийг ажилтнуудын цалинтай холбоотой зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,282.6</b>	<b>1,014.4</b>	<b>431.3</b>	<b>851.3</b>	<b>3.5</b>	<b>1,260.6</b>	<b>22.0</b>	<b>251.3</b>	<b>178.2</b>
Хүүгийн орлого	1,117.0	884.3	391.7	725.4	0.2	1,098.9	18.2	218.9	158.7
Хүүгийн бус орлого	143.6	114.9	28.3	115.3	3.3	140.1	3.5	30.0	17.1
Бусад орлого, олз	23.0	16.1	11.3	11.7	0.0	22.7	0.3	3.4	2.4
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>783.3</b>	<b>647.5</b>	<b>233.1</b>	<b>550.2</b>	<b>1.7</b>	<b>773.2</b>	<b>10.1</b>	<b>186.4</b>	<b>140.7</b>
Хүүгийн зардал	273.3	258.6	63.4	209.9	0.0	272.5	0.8	78.9	55.1
Хүүгийн бус зардал	322.8	242.4	104.6	218.3	1.7	316.2	6.6	65.0	54.3
Арилжааны зардал	2.2	1.5	0.8	1.4	0.2	2.2	0.0	0.1	0.0
Хани, үнэлгээний тэгшитгэлийн зардал	22.1	20.6	6.2	15.9	0.1	22.1	0.0	13.6	13.6
Хураамж, шимтгэлийн зардал	14.2	12.3	2.1	12.1	0.1	14.1	0.1	2.3	0.7
Үйл ажиллагааны бусад зардал	284.3	208.0	95.4	188.8	1.3	277.8	6.5	49.0	40.0
Эрсдэлийн сангийн зардал	85.9	60.2	33.1	52.7	0.0	84.1	1.8	23.8	20.1
Бусад зардал, гарз	12.0	7.3	5.9	6.1	0.0	11.7	0.3	0.9	1.7
ОАТ-ын зардал	89.3	78.9	26.0	63.2	0.0	88.7	0.6	17.9	9.5
<b>НИЙТ ЦЭВЭР ОРЛОГО</b>	<b>499.3</b>	<b>366.9</b>	<b>198.2</b>	<b>301.1</b>	<b>1.8</b>	<b>487.4</b>	<b>11.9</b>	<b>64.9</b>	<b>37.5</b>

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2024 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 555 ББСБ-ын 87.2% буюу 484 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 12.8% нь буюу 71 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 61 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 7 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ байна.

Хүснэгт 38 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр)

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /90 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /405 ББСБ/		ЗГВА /60 ББСБ/		Нийт /555 ББСБ/	
		√	X	√	X	√	X	√	X
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	90	-	404	1	60	-	554	1
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	90	-	404	1	60	-	554	1
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	90	-	405	-	60	-	555	-
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	89	1	402	3	60	-	551	4
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу )	84	6	380	25	60	-	524	31
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	90	-	398	7			547	8
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	90	-	405	-			555	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	90	-	403	2			553	2
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	89	1	399	6			548	7
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	404	1	XXX		554	1
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	404	1			554	1
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “Ш” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	90	-	403	2			553	2
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	405	-			555	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	90	-	404	1			554	1
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	89	1	397	8			546	9
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	87	3	XXX				552	3
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	90	-	403	2			553	2
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	89	1	395	10	58	2	542	13

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо, X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 31 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна. Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн зохистой харьцаа алдагдсан 23 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан ББСБ-д холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд Ногоон зээлийн багц нь нийт зээлийн багцын 2-оос дээш хувийг эзэлж байгаа ББСБ нь өөрийн хөрөнгийн 100 хувь хүртэл дүнгээр итгэлцлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжтой. Иймд итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцаа нь 80 хувиас давсан 3 ББСБ-ын зээлийн багц нь дээрх зохицуулалттай нийцэж байгаа эсэхэд холбогдох хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## Дүгнэлт

2024 оны III улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 555 ББСБ-аас 542 ББСБ тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 6 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 7 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2024 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 34,174 хувьцаа эзэмшигчдийн 555 ББСБ, 484 салбар нэгж, 12 төлөөлөгчийн газар, 5,855 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.9 сая харилцагч, 2.0 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

### Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар өсөж, банкны салбарын 10.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 99.4%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.9 пунктээр өссөн дүн юм.

2024 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсөж 6.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 84.2 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 36.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /155 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 55.6% буюу 1.6 тэрбум төгрөгөөр өсөж 2024 оны III улирлын байдлаар 4.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 212.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 4.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зээлийн багцын 90.1 хувийг буюу 4.7 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.7 хувийг буюу 190.0 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.2 хувийг буюу 322.2 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 1.1, 0.1 пунктээр өссөн бол чанаргүй зээлийн хэмжээ 1.3 пунктээр буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 512.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 47.7 хувьд буюу 244.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2024 оны III улирлын байдлаар 62 ББСБ үзүүлж байна. 2024 оны III улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1.6 сая зээлдэгчийн 1.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 78.1 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 23.9 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 801.0 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 11.3 дахин бага байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 50.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 63.4 хувийг өр төлбөрийн өсөлт, 36.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 2.0 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 2.2 дахин, бусад эх үүсвэр 57.0 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 51.0 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 18.0 хувиар тус тус өссөн байна.

### Ашигт ажиллагаа

2024 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 1.3 их наяд төгрөгийн орлого олж, 783.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 499.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 57.4% буюу 467.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 52.9% буюу 271.0 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 65.1% буюу 196.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

### Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2024 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 555 ББСБ-ын 87.2% буюу 484 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 12.8% нь буюу 71 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 61 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 7 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 31 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн зохистой харьцаа алдагдсан 23 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**